



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.5 дахь заалт, Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчөөс төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн, 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн балансын үнэ, 27,475,750.14 (хорин долоон сая дөрвөн зуун далан таван мянга долоон зуун тавин төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын дарга Г.Баатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө хүлээлцэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 05-ний өдрийн
204..... дугаар тогтоолын хавсралт

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэх
эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Балансын			Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					нэг бүрийн өнү	нийт үнэ			
						(төгрөг)			
1	Суудлын автомашин (Ниссан Патрол, СЭА 00-08, арал: JN1TESY61U0143721, хөдөлгүүр: VG33E)	ш	1	2013	40,000,000.00	40,000,000.00	27,475,750.14	12,524,249.86	
Нийт дүн			1			(дөчин сая)	(хорин долоон сая дөрвөн зуун далан таван мянга долоон зуун тавин төгрөг арван дөрвөн мөнгө)	(арван хоёр сая таван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун дөчин есөн төгрөг ерэн зургаан мөнгө)	